



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/19

Мэргэн хошуу


Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1, 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаагаа сунгуулах хүсэлт ирүүлсэн аж ахуй нэгжийн газар эзэмших эрхийн хугацааг нэгдүгээр хавсралтад заасны дагуу сунгасугай.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулсан газар эзэмшигчидтэй гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Г.Ганболд)-д, гэрээнд заасан зориулалт, нөхцөл шаардлагын дагуу газраа эзэмшихийг газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТБОЛД

Газар болон эзэмшилчийн мэдээлэл



Сумын Засаг даргын 2015 оны 14-р сарын 10-ны өдрийн 14-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Өмнөх Захирамжийн					
д/д	Иргэн /хуулийн этгээд/-ийн нэр	Регистр	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар
0	1	2	3	4	5
1	Дут чулуу ХХК	5396662	2020.04.22	35	0

Өмнөх газрын		Газрын			
Нэгж талбарын дугаар	Хугацаа /жил/	Хэмжээ /мкв/	Байршил	Эзэмшлийн зориулалт	Сунгах хугацаа /жил/
7	8	9	10	11	12
2318001358	5	1087041	2-р Бяг Хараат, Барилт Овоо-1	Ашиглах	5